

Монголын Эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбооны Тэргүүлэгчдийн хурлын 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 21 тоот тогтоолоор батлав.

МОНГОЛЫН ЭРЧИМ ХҮЧ, ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОЛБООНЫ ОНЫ ШИЛДЭГ ХОРОО, МЕНЕЖЕР, ГИШҮҮДИЙГ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

1. Журмын зорилго

- Салбарын Үйлдвэрчний эвлэлийн хороодын ажлыг дүгнэх, шилдэг тэргүүний идэвхтэн сонгуультаан гишүүдийг шалгаруулан урамшуулах, алдаршуулах, тэдний туршлагыг нийтийн хүртээл болгох, Үйлдвэрчний эвлэлийн анхан шатны байгууллагаас зохиож буй ажлын эрх зүйн чадамж, үр дүнг дээшлүүлэхэд журмын зорилго оршино.

2. Салбарын Үйлдвэрчний эвлэлийн холбооны оны шилдгүүд

- Үйлдвэрчний эвлэлийн холбооноос нийт хороодын жилийн ажлыг батлагдсан шалгуур үзүүлэлтээр дүгнэж шилдэг хороо 5, шилдэг менежер 2, шилдэг гишүүн 3-г шалгаруулна.
- Үйлдвэрчний эвлэлийн анхан шатны байгууллагууд ажлын тайлан, гэрээний үүргийн биелэлтээ гаргаж 3-аас илүүгүй хуудсанд багтаан бичиж, шалгуур үзүүлэлтийн дагуу ажлаа өөрсдөө дүгнэн 12 дугаар сарын 15-ны дотор холбооны ажлын албанд ирүүлнэ. Тогтоосон хугацаанд тайлангаа ирүүлээгүй бол дүгнэгдэхгүй.
- Тайланд тусгасан хийсэн ажилтай холбоотой материалыг хуулбараар ирүүлнэ. /Жишээ нь: Цалин нэмэгдүүлсэн тушаал, Шүүх, МХГ, ХМТК-ийн шийдвэр/ гэх мэт
- Тухайн байгууллагын “Хамтын гэрээ” шинэчлэгдсэн, нэмэлт өөрчлөлт орсон тухай бүрд хуулбарыг Үйлдвэрчний эвлэлийн холбоонд ирүүлэх бөгөөд энэ нь ажил дүгнэхэд үндсэн үзүүлэлт болно. Гэрээний хэрэгжилтийг ҮЭХ, захиргаа хамтран дүгнэсэн хувиар үнэлнэ.
- Анхан шатны хороодын ажлыг холбооны ажлын албаны ажилтнууд байр эзлүүлэн дүгнэж, шилдэг менежер гишүүдийг шалгаруулах тухай саналаа Тэргүүлэгчдийн хуралд оруулж, Тэргүүлэгчдийн хурал шалгаруулж зарлана.

3. Оны шилдгүүдийг дүгнэх үзүүлэлтүүд

- Монголын Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль, салбарын Үйлдвэрчний эвлэлийн холбооны дүрмийг хэрэгжүүлэн байгууллага, гишүүдийн хуулиар олгогдсон эрхийг хамгаалах талаар бусад байгууллагуудад нэвтрүүлэхүйц санал санаачлага гарган тогтвортой ажлын байр, хөдөлмөрлөх эрх, амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд үр дүнд хүрэхүйц ажлыг хийж гүйцэтгэж онцгой санал санаачилга гаргасан Үйлдвэрчний эвлэлийн хорооны даргыг “Оны шилдэг менежер”-ээр
- Монголын үйлдвэрчний эвлэлийн гишүүнийхээ манлайллыг өндөрт өргөн ҮЭ-ийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлж хамт олныхоо төлөө ажилласан, удирдах байгууллагаас ажлын амжилтыг үнэлэхэд хамт олондоо хүлээн зөвшөөрөгдөхүйц гишүүнийг “Оны шилдэг гишүүн”-ээр
- Дараах шалгуур үзүүлэлтүүдийг ханган биелүүлж, онооны нийлбэрээр эхний 5 байр эзэлсэн Үйлдвэрчний эвлэлийн анхан шатны байгууллагыг “Оны шилдэг үйлдвэрчний эвлэлийн хороо”-гоор тус тус шалгаруулна.

Д/д	Дүгнэх үзүүлэлтүүд	Дүгнэх журам, өгөх оноо
1	Салбарын хамтын хэлэлцээрийн хэрэгжилт	Хамтын гэрээндээ хэлэлцээрт заасан заалтуудыг бүрэн тусгасан бол +20 оноо. Тусгагдаагүй заалт бүрийн тоогоор -2 оноо
2	Хамтын гэрээний хэрэгжилт, үр дүн	Гэрээний биелэлт 90-ээс дээш хувьтай бол +10 оноо Хамтын гэрээ байгуулахдаа шинээр оруулсан заалт бүрийн тоогоор +5 оноо Цалин хөлсийг нэмэгдүүлсэн хувь тутамд +3 оноо Нөхцөлийг дээрдүүлсэн заалт бүрийн тоогоор +2 оноо
3	Тухайн онд салбарын хэмжээнд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх талаар хийсэн ажил	Тухайн жилийн зорилт, салбарын Үйлдвэрчний эвлэлийн холбооноос бусад хороодын туршлагыг нэвтрүүлэх талаар өгсөн үүрэг чиглэлийг хийж гүйцэтгэсэн бол +10 оноо
4	Ажилтнуудын цалин хөлсийг нэмэгдүүлэх талаар хийсэн ажил, үр дүн	Гишүүдийн бодит орлогыг өсгөхтэй холбогдуулан хууль дүрмийн зөрчлийг арилган гаргасан шийдвэр бүрд +5 оноо
5	Үйлдвэрчний эвлэлийн байгууллага гишүүдийн эгнээг өсгөх талаар хийсэн ажил	Гишүүдийн тоог өмнөх оны хэмжээнээс бууруулаагүй бол +8 оноо Өсгөсөн бол +8 оноо ба өсгөсөн хувь тутамд +1 оноо Орон нутаг, харьяалсан салбар, компани нэгжид анхан шатны байгууллага байгуулсан бол хурлын шийдвэр, хамтын гэрээг үндэслэн +15 оноо
6	Салбарын үйлдвэрчний эвлэлийн холбооны хөрөнгийн чадавхыг өсгөх талаар хийсэн ажил	Хариуцлага үр дүнгийн гэрээгээр хүлээсэн татварыг бүрэн төлсөн бол +10 оноо Төлөх татварын хэмжээг нэмэгдүүлсэн тохиолдолд гэрээнд заасан татварын хувьтай харьцуулан илүү төлөлтийн хувь тутамд +5 оноо Эв санааны нэгдлийн санд хөрөнгө хуримтлуулсан бол +10 оноо /хураасан татварт ногдох хувиар төлсөн/
7	Гишүүдийн хөдөлмөрлөх эрхийг хангах талаар хийсэн ажил	Гишүүдийн зөрчигдсэн эрхийг хамгаалж шүүх, МХГ, ХМТК, дарга захирал нарт тавьж шийдвэрлүүлсэн асуудал бүрд +8 оноо
8	Үйлдвэрчний эвлэлийн холбооны ажилд оролцсон байдал /тайлан мэдээ/	Хурал зөвлөгөөн зохион байгуулсан арга хэмжээнд оролцсон тохиолдол бүрд +3 оноо /УЗ хурал орохгүй/ Тайлан мэдээ хариутай албан бичигт хариу өгсөн тохиолдол бүрд +5 оноо Холбооноос томилсон ажлын хэсэг, комисст орж асуудлыг бүрэн шийдвэрлэсэн тохиолдол бүрд +5 оноо
9	Үйлдвэрчний хорооны санаачилгаар хийсэн үр дүнд хүрэхүйц шинэлэг ажил	Дээрх үзүүлэлтүүдэд ороогүй үр дүнд хүрсэн ажилд 5-20 оноо

10	ХАБЭА, ажиллаж амьдрах зохистой орчинг бүрдүүлэх чиглэлээр хийсэн ажил	Ажлын үр дүнг харгалзан 5-20 оноо
----	--	-----------------------------------

Хариуцсан байгууллагад нь хүнд, бүлэг, ноцтой, хүний амь нас эрсэдсэн, осол аваар гарсан, ажлын арга барил ёс зүйн талаар хамт олноос нь гомдол санал ирүүлсэн, ажил хүлээн аваад 6 сар ажиллаагүй дарга нарын ажлыг дүгнэх бөгөөд шалгаруулалтад орох эсэхийг Тэргүүлэгчийн хурлаар шийдвэрлэнэ.

4. Урамшуулах, сурталчлах

Оны шилдэг байгууллага гишүүдийн шагналыг салбарын ҮЭХ-ны шинэ жилийн баяраар гардуулна.

Оны шилдэг “Үйлдвэрчний эвлэлийн хороо”

- I-р байр Батламж- 500.000 төгрөг
- II-р байр Батламж- 400.000 төгрөг
- III-р байр Батламж- 350.000 төгрөг
- IV-р байр Батламж- 300.000 төгрөг
- V-р байр Батламж- 250.000 төгрөг

Оны шилдэг менежер

Батламж- 300.000 төгрөг

Оны шилдэг гишүүн

Батламж- 200.000 төгрөг

- Оны шилдэг байгууллага, гишүүний ажлын амжилт, туршлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.
- Шилдгээр шалгарсан хороодын дарга, шилдэг менежерүүд хийсэн ажил үр дүн туршлагаа нийт хороодын дарга нарт ажлын тайлан тавина.

---oOo---